



BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛТ ХК

2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ТАНИЛЦУУЛГА

Монгол Базальт ХК нь Монгол Улсад базальт чулуун хөвөн дулаан тусгаарлах материал үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрлэгч компани бөгөөд барилга, дэд бүтэц, эрчим хүч, аж үйлдвэрийн салбарын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Компанийн бүтээгдэхүүн нь олон улсын стандартын шаардлагыг хангаж, галд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй байдлаараа зах зээлд өрсөлдөх чадварыг бий болгож байна. Энэхүү тайлан нь 2025 оны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн гүйцэтгэл, засаглал, эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжлийн бодлого болон ирээдүйн стратегийг олон нийт, хөрөнгө оруулагчид, харилцагч талуудад ил тод танилцуулах зорилготой.

Алсын хараа

Галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тогтвортой нийгмийг цогцлооно.

Урт хугацааны зорилт

Тогтвортой хөгжил

Эрчим хүчний хэмнэлттэй технологи ашиглан дулаалгын шинэлэг бүтээгдэхүүнийг тасралтгүй судалж, хөгжүүлнэ. Байгальд ээлтэй дулаалгын шийдэлд анхаарлаа хандуулж, үр ашигтай үйлдвэрлэлийг цогцлоож байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгана.

Зах зээлийн манлайлал

Шинэ базальт файбер зах зээлийг тодорхойлж, R&D хөрөнгө оруулалт, технологийн хамтын ажиллагааг ашиглан орлогын тогтвортой өсөлтийг бий болгоно. Цаашлаад бүтээгдэхүүний төрөлжилтийг нэмэгдүүлж салбарын тэргүүлэгч компани болно.

Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн

Галын өндөр эсэргүүцэл, эрчим хүчний хэмнэлт, акустик тав тухыг хангах дэвшилтэт дулаалгын шийдлүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.





КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

Монгол Базальт ХК

Байгуулагдсан огноо:

2007

Вэбсайт, фэйсбүүк хаяг:

www.basaltwool.mn
Mongol Basalt JSC

Үйл ажиллагааны чиглэл:

Чулуун хөвөнгийн үйлдвэр, үйлдвэрийн хүчин чадал: **Цагт 2.5 тн**

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 403
тоот

Утас, и-майл хаяг:

75114444
monbasalt@rockwool.mn



УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

ТУЗ-ийн дарга:


Л.Ариунболд

Гүйцэтгэх захирал:

А.Энхгэрэл

Ажилчдын тоо:

85



ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хувьцааны симбол код:

MSE:MBW / 544

МХБиржид бүртгэгдсэн:

2018.04.05

Нийт гаргасан хувьцаа:

56,417,000 ширхэг





ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

А.Энхгэрэл СЕО

Эрхэм хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд ээ, 2025 он нь Монгол Базальт ХК-ийн хувьд зах зээлийн сорилт ихтэй хэдий ч дотоод чадавхаа бэхжүүлж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн чухал жил байлаа.

Бид зардлын сахилга батыг сайжруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэхэд онцгой анхаарсан. Үүний үр дүнд борлуулалтын орлого буурсан ч цэвэр ашиг өссөн эерэг үр дүнд хүрсэн.


Цаашид бид инновац, экспорт, ногоон технологид суурилсан өсөлтийн стратегийг хэрэгжүүлнэ.

БАРИЛГЫН САЛБАРЫН ТОЙМ


Салбарын өсөлт, ДНБ-д эзлэх хувь

Манай улсын эдийн засгийн өсөлт тодорхой салбараас ихээхэн хамаарч, бусад салбарт өсөлт ажиглагдахгүй байгаагийн тод жишээ нь барилгын салбар юм. Эдийн засгийн өсөлтийг бүрдүүлж буй гол бүтэц нь уул уурхайн салбар байна. Сүүлийн 10 гаруй жил Монгол Улсын эдийн засгийн мөчлөг эрдэс баялгийн үнэ, борлуулалтын орлогоос хамаарах болсон. Гэвч барилгын салбарын өсөлт нь ДНБ-ийн өсөлтийн 1 хүрэхгүй хувийг, барилгын салбар дангаараа нийт ДНБ-ийн 3-4 хувийг бүрдүүлж байгаагаас гадна эзлэх хувь нь 2020 оноос хойш буурч байна. Монгол Улсын ДНБ-ийн хэмжээ 2023 онд 2015 оны дүнгээр 30.45 их наяд төгрөгт хүрсний 898 тэрбум төгрөг (2.9%)-ийг барилгын салбар бүрдүүлж байжээ.

ДНБ-ий салбарын бүтэц (2016-2023)



ДНБ болон барилгын салбарын өсөлт (2016-2023)



Барилгын салбарын макро үзүүлэлтүүдийн тойм

Эдийн засгийн статистик мэдээнд тулгуурлан барилгын салбарыг дүгнэвэл:

- 2023 оны байдлаар барилгын салбар нь ДНБ-ийн 2.9 хувийг эзэлж байсан бол жилийн өсөлт нь 0.6 хувь байсан байна. Тус салбарын өсөлт нь ДНБ-ийн өсөлтийн 1 хүрэхгүй хувийг бүрдүүлж байгаагаас гадна ДНБ-д эзлэх хувь нь 2020 оноос хойш тасралтгүй буурсан үзүүлэлттэй байна.
- Цар тахлаас шалтгаалан салбар нь 2021 онд 22.8 хувиар буурсан бөгөөд одоог хүртэл цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байна. Түүнчлэн, салбарын өсөлт нь төрөөс хэрэгжүүлж буй төсөл, барилгын ажлаас ихээхэн хамааралтай байдаг.
- Салбарын бүтээмж нь 2023 оны байдлаар 11.9 сая төгрөг байсан бөгөөд энэ нь улсын дундаж бүтээмжээс 2.1 дахин бага үзүүлэлт юм.
- 2023 оны байдлаар нийт 4.41 их наяд төгрөгийг барилгын объектын төсөвт өртөгт зарцуулсан бөгөөд үүнээс орон сууцанд зарцуулсан нь 2.06 их наяд төгрөг байна. 2020 оноос хойш орон сууцны барилгын тоо буурч байгаа ч төсөвт өртөг нь ихсэж байгаа бөгөөд энэ нь илүү өндөр өртөгтэй, том талбайтай орон сууцны барилга баригдах болсонтой холбоотой байна.
- 2022 оны байдлаар нийт 77,527 ажилтан барилгын салбарт ажиллаж байсан бөгөөд энэ нь нийт ажиллагсдын 6.6 хувийг эзэлж байна. 2022 онд улсын дундаж цалин 1.5 сая төгрөг байсан бол барилгын салбарын дундаж цалин 1.43 сая төгрөг байсан байна

Барилгын дулаалгын материалын зах зээл

Монгол улс нь гадаад худалдааны хувьд импорт давамгайлсан орон. Үүнээс дотоодын дулаалгын материалын хэрэглээний 70 гаруй хувийг импортоор хангадаг ба БНХАУ-аас чулуун хөвөн болон хөөсөнцөр хавтан, ОХУ-аас шилэн хөвөнг импортолдог байна.



Дотоодын барилгын дулаалгын материалын хэрэглээний 70 гаруй хувь болох импортоор 43,000 тонн орчим барилгын дулаалгын материал худалдаж авдаг бөгөөд үүний дийлэнх хэсгийг Expanded Polystyrene (EPS) буюу хөөсөнцөр хавтан эзэлдэг. Канад, Франц, Энэтхэг, Тайвань, Нью-Йорк хот зэрэг дэлхийн олон улс орон, хотууд EPS хавтанг ашиглахыг хориглосон эсвэл хязгаарласан байдаг. Учир нь:

- Галд өртөмтгий: Ихэнх хөөсөнцөр нь шатамхай бөгөөд өндөр температур эсвэл галд өртөх үед хорт утаа ялгаруулдаг;
- Байгаль орчны асуудал: Хөөсөнцрийг үйлдвэрлэхэд ихэвчлэн нөхөн сэргээгдэхгүй нөөц болох нефть химийн бодисыг ашигладаг;
- Даацын хэрэглээнд тохиромжгүй гэсэн шалтгаануудаас үүдэлтэй.



ҮЙЛ АЖИЛЛАГАА



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 онд компани үйлдвэрлэлийн суурь чадавхийг бэхжүүлэх, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, бүтээгдэхүүний чанарыг тогтворжуулахад чиглэсэн стратегийн хөрөнгө оруулалтуудыг амжилттай хэрэгжүүллээ. Тайлант хугацаанд 2164 тн Чулуун хөвөн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, борлуулалтын үндсэн орлогыг бүрдүүлсэн. Үйлдвэрийн хэмжээнд хийгдсэн бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн туршилт, тохируулгын ажлуудын үр дүнд үйлдвэрлэлийн шугамын тогтвортой байдал сайжирч, төлөвлөгдөөгүй зогсолт, технологийн алдагдал буурч, нэгж бүтээгдэхүүний өөрийн өртгийг дунд хугацаанд бууруулах бодит суурь бүрдлээ.

Эдгээр сайжруулалтууд нь:

- орлогын өсөлтийг тогтвортой дэмжих,
- ашигт ажиллагааг сайжруулах,
- мөнгөн урсгалын хэлбэлзлийг бууруулах,
- хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх

эдийн засгийн боломжийг бүрдүүлж байна.

Цаашид компани өндөр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх, дотоодын зах зээл дахь байр сууриа бэхжүүлэх, экспортын чиглэлд үе шаттай тэлэх, зардлын бүтцийг оновчлох замаар хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад хүртэх урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх стратегийг хэрэгжүүлэн ажиллах болно.



Хүний нөөц – Гол үзүүлэлтүүд (2025 он)


- Дундаж ажилтны тоо: 84 хүн
- Хүний нөөцийн эргэц: 2.5% (2024 оноос 2 нэгж хувиар буурсан)
- Шинээр ажилд авсан: 21
- Цалингийн нийт зардал: 2.24 тэрбум төгрөг (+3%)
- Дотоод аудит: 2 удаа | Нэгдсэн менежментийн тогтолцооны Магадлан аудит: 1 удаа
- 2026 оны анхаарах чиглэл: сургалт хөгжүүлэлт



ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 онд “Монгол Базальт” ХК нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг тогтвортой нэмэгдүүлэх, технологийн шинэчлэлийг үр ашигтай хэрэгжүүлэх стратегийн зорилттой уялдуулан хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаагаа үе шаттайгаар хэрэгжүүллээ. Компанийн хүний нөөцийн тогтвортой байдал сайжирч, эргэц 2.5 хувь хүртэл буурсан эерэг үзүүлэлт гарлаа. Ажилд авах идэвх өмнөх оноос буурсан хэдий ч харуул, жолооч зэрэг үйл ажиллагааны чухал албан тушаалуудад тогтвор суурьшил сул хэвээр байна. Тайлант хугацаанд компанийн инженер, техникийн ажилтнууд Узбекистан улсын Жиззах мужид байрлах ижил төрлийн үйлдвэрлэл эрхэлдэг Базальт Узбекистан компанитай туршлага солилцож, хамтран ажилласнаар үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмжийн ашиглалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн ба давхардсан тоогоор 602 ажилтныг 916 хүн цагийн сургалтад хамрууллаа. 2026 онд үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангах хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, сургалт хөгжлийг тогтмолжуулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүний нөөцийн харьцуулалт



Ажилтнуудын хүүхдүүдийн дунд “Миний аав, ээж, эмээ, өвөөгийн ажил” нэртэй гар зургийн уралдааныг зохион байгууллаа.

СУРГАЛТ, ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ

Сургалт

2025 оны 1,2 сар - байшин сууцаа дахин дулаалах замаар утааг бууруулах талаар мэдээлэл хүргэх зорилго бүхий “Утааг дулаалж ялна” сэдэвт сургалтуудыг СХД-ийн 4, 5, 7, 10, 26, 33 хороодууд зохион байгуулсан ба нийт 571 иргэнийг хамруулав.

2025 оны 3 сар - Барилга угсралтын компани, бригадууд, төсөл хэрэгжүүлэгчид болон салбарын мэрэгжилтэн нарын дунд термопассив хаус бүтэц элемент угсрах зааварчилгаа болон технологийн зөвшилцөх уулзалтыг зохион байгуулав.

2025 оны 4 сар- Дархан хотын иргэдэд пассив панел хийц технологи танилцуулах нээлттэй өдөрлөг зохион байгуулав.



Үзэсгэлэн арга хэмжээ

2025 оны 4 сар :

- Барилга экспо 2025 /зохион байгуулагч-Барилга.мн/
- Тогтвортой хөгжил ногоон ирээдүй /зохион байгуулагч-Төрийн банк ХК/
- Чингэлтэй дүүргийн Амины орон сууцны мэдээллийн төвийн нээлтийн арга хэмжээ /зохион байгуулагч-БХБОСЯ/
- Оюуны өмчийн өдөрлөг /Гаалийн ерөнхий газар/

2025 оны 5 сар:

- Дулаан байшин өдөрлөг /зохион байгуулагч-БХБОСЯ/
- Дархан барилга экспо 2025



Шүршдэг чулуун хөвөнгийн стандарт

MNS GB/T 26746:2025 Дулаан тусгаарлалтын шүршдэг эрдэс хөвөн, MNS JC/T 903:2025 Утаслаг ширхэглэл эрдэс хөвөн стандартуудыг орчуулж стандарчлалын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж батлуулав.



ДУЛААНБААТАР АЯН - СУРГАЛТ ӨДӨРЛӨГ

“Дулаанбаатар” аяны хүрээнд Монгол Базальт ХК нь УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц, түүний ажлын хэсэг болон нийслэлийн 6 дүүргийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудтай хамтран 2000 гаруй иргэдэд 14 удаагийн дулаалгын сургалт, зөвлөгөө арга хэмжээг зохион байгууллаа.



Сүхбаатар дүүрэгт 11-20-р хороодын нийт 500 гаруй иргэдэд 4 удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.



Чингэлтэй дүүрэгт 7-12 болон 20-22-р хороодын 600 гаруй иргэдэд 4 удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.



Баянгол дүүрэгт 9-11, 16, 20-23 болон 29-р хороодын 250 гаруй иргэдэд 2 удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.



Налайх дүүрэгт 1-8-р хороодын 120 гаруй иргэдэд 1 удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.



Хан-Уул дүүрэгт 5-16 болон 21-р хороодын 140 гаруй иргэдэд 2 удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.



Баянзүрх дүүрэгт 2, 5, 8-24 болон 27-42-р хороодын 460 гаруй иргэдэд 1 удаагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2025 оны эцсийн байдлаар **43.97** тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны эцсийн үлдэгдлээс **2.1** хувиар өссөн байна.

Эргэлтийн хөрөнгө **10.98** тэрбум төгрөг болж, өмнөх оноос 4.32 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалтын авлага болон мөнгөн хөрөнгийн өсөлттэй холбоотой.


Нийт өр төлбөр 12.92 тэрбум төгрөг, үүнээс богино хугацаат өр төлбөр 10.36 тэрбум төгрөг, урт хугацаат өр төлбөр 2.56 тэрбум төгрөг байна. Эздийн өмч **31.05** тэрбум төгрөгт хүрч, тайлант үеийн цэвэр ашгийн нөлөөгөөр өссөн байна.

Тайлант 2025 онд компанийн борлуулалтын цэвэр орлого **9.26** тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3.02 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүний шалтгаан нь зах зээлийн эрэлт, барилгын салбарын идэвхжил буурсан болон үнийн дарамттай холбоотой.

Борлуулалтын өртөг **6.59** тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2.39 тэрбум төгрөгөөр буурч, зардлын хяналт сайжирсан эерэг үзүүлэлт гарсан.

Нийт ашиг 2.56 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр ашиг 147.4 сая төгрөг болж, өмнөх оноос 10.7 сая төгрөгөөр өссөн байна.

БОРЛУУЛАЛТ / САЯ.ТӨГРӨГ



Зах зээл ба борлуулалтын үйл ажиллагаа


Барилгын салбарын идэвхжил буурсантай холбоотойгоор зах зээлийн нийт эрэлт буурсан боловч компани харилцагчийн баазаа хадгалж, урт хугацааны гэрээт харилцааг үргэлжлүүлэв.

Маркетингийн хүрээнд инженер, зураг төслийн байгууллагуудтай хамтран техникийн сургалт, танилцуулга зохион байгуулсан.

Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Утга
Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	0.3314
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/	0.4752
Нийт хөрөнгийн эргэц /ROTA/	0.2081
Нэгж хувьцааны өгөөж /EPS/	2.6135
Үнэ ашгийн харьцаа (P/E Ratio)	79.9627





Caring for soil
caring for the
planet,
**with
stone wool.**

БАЙГАЛЬ ОРЧИН

БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО, УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Компанийн үйл ажиллагаа нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, холбогдох хууль тогтоомж, стандарт шаардлагыг бүрэн хангах зарчимд тулгуурладаг.

2025 онд байгаль орчны менежментийн дотоод журам, хяналт-үнэлгээний тогтолцоог сайжруулж, ажилтнуудын мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх сургалт, зааварчилгааг тогтмол зохион байгууллаа.

2025 онд үйлдвэрийн нийт эрчим хүчний хэрэглээ 681,504 кВт.цаг байсан нь өмнөх онтой харьцуулахад 20% буурсан. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг эрчим хүчний хэмнэлттэй болгох, үйлдвэрлэлийн горимыг оновчлох замаар нэгж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний зарцуулалтыг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Үүнд:



- Тоног төхөөрөмжийн тохируулга, шинэчлэлт сайжруулалт
- Технологийн процессыг оновчтой болгох туршилт тохируулга

Тайлант онд нийт 3,192 м³ ус ашигласан бөгөөд үйлдвэрлэлийн процессын усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлсэн. Байгаль орчны мониторингийн хэмжилт хийлгэж, байгаль орчин нийгмийн нарийвчилсан үнэлгээний тайланг Экологийн бүтээмж ХХК-р хийлгүүлж Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамаар батлуулан холбогдох зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



2025 онд байгаль орчны чиглэлээр 1 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 50 ажилтан хамрагдсан. Сургалтын хүрээнд:

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ), Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) сургалт
- Хаягдал ангилан ялгах
- Эрчим хүч, ус хэмнэх дадал
- Аюултай хог хаягдлын зохистой менежмент сэдвүүдийг тусгав.

Эрчим хүчний хэрэглээ





Усны хэрэглээ





Түлшний хэрэглээ





Хог хаягдал -Энгийн





Хог хаягдал-Аюултай



Дулаан хангамж



Тос тослох материал



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА БОНЗ

Монгол Базальт ХК нь НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ” (UN Global Compact) болон Тогтвортой санхүүжилтийн холбоонд нэгдэн орох үүрэг, амлалтыг хүлээн ажиллаж байгаа бөгөөд бизнес ба хүний эрхийн зарчим, шаардлагуудыг компанийн удирдлагын тогтолцоо болон өдөр тутмын үйл ажиллагаанд шат дараатайгаар нэвтрүүлж байна. Энэхүү алхам нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, хөдөлмөр, байгаль орчин, авлигын эсрэг үйл ажиллагааны 10 зарчмыг хэрэгжүүлэх компанийн эрмэлзлийг илэрхийлэхийн сацуу, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг төлөвшүүлэхэд чиглэсэн стратегийн чухал шийдвэр юм.

Тус компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 12-т нийцэж, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж байна. Тогтвортой хөгжил, байгаль орчны хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй санаачилгууд Чулуун хөвөн дулаалгын материалын үйлдвэрлэлээр Монгол Улсад тэргүүлэгч “Монгол Базальт” ХК нь байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагаа явуулах, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлд бодитой алхмууд хийсээр байна.

Аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид тэгш боломж, жигд оролцоо, хүнд ээлтэй ажлын байр, эрүүл аюулгүй хүн, тогтвортой ханган нийлүүлэлт

Байгууллагын соёл төлөвшсөн, ёс зүй, үнэт зүйлсээ эрхэмлэгч, хүний эрхийг дээдлэгч, эрх зүйн нийцлийг хангагч, нээлттэй мэдээлэл солилцогч

Байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах, хог хаягдал бууруулах төлөвшсөн тогтолцоотой

**SOUND
ABSORBENT**



**FIRE
RESISTANT**



**WATER
REPELLENT**



Компанийн эрхэм зорилгын хүрээнд бид:

- Галын аюулгүй байдал, эрчим хүчний хэмнэлт, дотоод орчны тав тухыг хангасан тогтвортой бүтээгдэхүүн, шийдлүүдийг санал болгож, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж байна.
- Тогтвортой хөгжил болон ногоон үйлдвэрлэлийн зарчмыг дэмжих үүднээс дахин боловсруулалт, дугуй эдийн засгийн чиглэлээр хэд хэдэн санаачилга хэрэгжүүлж эхлээд байна.

Тухайлбал, чулуун хөвөнгийн үйлдвэрлэлийн явцад үүсэх хаягдлыг дахин боловсруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, түүгээр дамжуулан байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, нөөцийг үр ашигтай ашиглах зорилго тавин ажиллаж байна.


Эдгээр санаачилгууд нь зөвхөн компанийн нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэх төдийгүй Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн чухал үйл ажиллагаа болж байна.

BASALTCYCLE ДАХИН БОЛОВСРУУЛАХ ХӨТӨЛБӨР




SDG 12: **NET ZERO**
BASALTCycling Roadmap


Түүхий эд /базальт, шохойн чулуу/




Basaltwool дулаан тусгаарлагч хавтангийн үйлдвэрлэл




Барилга



Тээвэрлэлт



Барилга нураалт



SDG 13: Нүүрстөрөгчийн хэмнэлттэй барилга, байгууламжийн үйлдвэрлэлийг дэмжих



SDG 11: Орлогд нийцсэн орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих




SDG 7: Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



SDG 3: Дуу чимээний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх



Дахин боловсруулсан түүхий эд



Үйлдвэрлэлийн хог хаягдал

Барилгын хаягдал чулуун хөвөн, үйлчлүүлэгчдээс хаягдсан материалыг тээвэрлэх

Монгол Базальт ХК нь өндөр чанарын, ногоон барилгын дулаалгын материалуудыг Европын Холбооны галын А1 зэрэглэлийг хангаж нийлүүлж байна. Хариуцлагатай барилгын салбарыг Инновациар дэмжинэ.



НОГООН ТӨСӨЛ GROWOOL

Монгол Базальт ХК нь 2019 оноос GROWOOL чулуун хөвөн суурилсан хөрсгүй тариалалтын (гидропоник) технологийг хөгжүүлж, усны хэрэглээг бууруулан байгаль цаг уураас үл хамааран жилийн дөрвөн улиралд тогтвортой ургац хураах боломжийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.



2021 онд тус компани анхны монгол хэл дээрх гидропоник технологийн гарын авлага, зааварчилгаа-г хэвлэн нийтэлж, иргэд, аж ахуй нэгжүүдэд сургалт, зөвлөгөө, мэдээлэл түгээн хэрэгжүүлж байна. 2023 онд төслийн хүрээг өргөжүүлж, дөрвөн улирлын гидропоник хүлэмжийн байгууламж барих ажлыг эхлүүлсэн бөгөөд 2026 онд ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна.

Тогтвортой хүнсний үйлдвэрлэл

Монгол улсын хүнсний ногооны 80%-г импортын бүтээгдэхүүн эзлэж байна. COVID-ын нөлөөгөөр монгол улсад өргөн хэрэглээний хүнсний ногооны үнэ нэмэгдэж, хомсдол бий болж буй энэ цаг үед бид иргэн бүр хүнсний ногоогоо өөрөө ургуулах боломжтойг сурталчилан таниулж байна.

Монгол улсын цэвэр усны хэрэглээний 12%-г усалгаатай тариалан буюу газар тариаланд ашигладаг бөгөөд базальт чулуун хөвөн ашигласнаар газар тариаланд ашиглаж буй усыг 80-90%, тариалалтын талбайн хэмжээг 70% хүртэл хүртэл бууруулах бүрэн боломжтой юм.

Мөн жилийн дөрвөн улиралд уур амьсгал, цаг агаарын нөлөөлөлөөс шалтгаалахгүйгээр тогтвортой хүнс үйлдвэрлэх боломжтой тул тогтвортой хөгжлийн зорилтын 2, 6 болон 15 дугаар зорилтуудыг бүрэн хангаж чадсан **НОГООН** төсөл юм.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4 дүгээр сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор, нэгж хувьцаанд 2.42 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, нийт 136,529,140 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар баталж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК (ҮЦТХТ ХХК)-ээр дамжуулан 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд амжилттай тараан байршуулсан болно.

Монгол Базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн зарчим-ыг баримтлан, олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг тэнцвэртэй хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэцтэйгээр ажиллаж байна.

2025 оны жилийн эцсийн Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайлангаар нийт 72 онооноос 71 оноо буюу 98.6%-аар үнэлсэнийг СЗХ-ны компанийн засаглал, комплайнсын хэлтэсээс хянан баталгаажуулж 65 оноо буюу 90.2 хувиар “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлж, Монгол базальт ХК нь компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээгээр нээлттэй хувьцаат компаниудын 12-д эрэмбэлэгдэх боллоо. Цаашид компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг улам сайжруулах, түүний хэвшил, тогтвортой байдлыг бий болгох, компанийн засаглалын соёлыг гүнзгийрүүлэх зорилтын хүрээнд тогтвортой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



Хувьцаа эзэмшигчдийн /тоо- 2342 / бүтэц



НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

№	Нэр	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Л.Ариунболд	35.7%
2	П.Сайнбилэг	13.3%
3	А.Энхгэрэл	7%
4	А.Энхмаа	7%
5	А.Энхжин	7%



ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Л.Ариунболд



Б.Шаравсамбуу



Хан Гю Бунг



П.Сайнбилэг



Г.Ганзориг



А.Энхгэрэл

Хараат бус гишүүн:



Ш.Энхтөр



П.Нямдорж



Ч.Зоригтбаатар

КОМПАНИЙН ДОТООД ХЯНАЛТ

"Монгол Базальт" ХК нь үйл ажиллагаандаа Олон улсын чанар (ISO 9001), байгаль орчин (ISO 14001) болон ХАБЭА-н стандартуудын шаардлагыг хангасан Нэгдсэн менежментийн тогтолцоог (НМТ) хэрэгжүүлэн ажилладаг.

Нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) шаардлага үр нөлөөтэй хэрэгжиж байгааг бодитоор үнэлэх, тасралтгүй сайжруулалтыг дэмжих зорилгоор дотоод аудитын тогтолцоог тууштай хэрэгжүүлж, 2025 онд төлөвлөгөөт аудитыг нийт 2 удаа амжилттай зохион байгууллаа. Тайлант хугацаанд аудитыг "Асуух-Ажиглах-Шалгах" арга зүйгээр, батлагдсан "Шалгах хуудас"-ны дагуу явуулж, үйл ажиллагааны бүх шатанд нотолгоонд суурилсан үнэлгээг өгснөөр тогтолцооны "Тохирол"-ыг баталгаажуулж, илэрсэн үл тохирол болон анхаарах зүйлсийг нэгтгэн дүгнэв. Эдгээр аудитын дүгнэлтэд үндэслэн "Сайжруулах арга хэмжээний төлөвлөлт"-ийг (MBW-IMS-12.00.05) боловсруулж, Гүйцэтгэх захирлаар батлуулан, үйл ажиллагааны үл тохирлыг засан залруулах, сайжруулах ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.



ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

"Монгол Базальт" ХК нь оролцогч талуудтайгаа тогтвортой үнэ цэнийг бүтээхийн тулд харилцан итгэлцэлд суурилсан нээлттэй бодлогыг баримтлан ажилладаг. Энэхүү стратегийн хүрээнд компанийн ашигт ажиллагаа, засаглалын ил тод байдлыг эрхэмлэгч хувьцаа эзэмшигчид, стратегийн удирдлагаар хангагч ТУЗ, болон НМТ-г гардан хэрэгжүүлэгч гүйцэтгэх удирдлага, ажилтнууд зэрэг дотоод талуудаас гадна чанартай бүтээгдэхүүн хүлээгч харилцагчид, бизнесийн түнш нийлүүлэгчид, хууль тогтоомжийн нийцлийг хянагч төрийн байгууллагууд болон орон нутгийн иргэд гэсэн гадаад оролцогч талуудыг тодорхойлон хамтран ажиллаж байна. Компани нь мэдээллийн ил тод байдлыг хангах, талуудын нөлөөллийн материаллаг байдалд эрсдэлийн шинжилгээ хийх, эргэх холбооны сувгаар дамжуулан үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зарчмыг баримталдаг. Түүнчлэн оролцогч талуудын удирдлагын матрицыг ашиглан тэдгээрийн нөлөөлөл болон сонирхлын түвшинд тулгуурлан хянах, сэтгэл ханамжийг хангах, удирдах, мэдээллээр хангах зэрэг оновчтой тактикуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ


Хаалтын ханш
/2025.12.31/ **+11.14₮** **197.84**

←

208.98 Өмнөх ханш
/2024.12.31/




Тайлант хугацаанд Монгол Базальт ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааны дээд ханш 209.99 төгрөг, доод ханш 161.03 төгрөг байсан бол 2025 оны хаалтын ханш 208.98 төгрөгт хүрсэн байна. Тайлант хугацаанд сард дунджаар 85,359 ширхэг хувьцаа арилжаалагдсан бөгөөд нийт 1,024,311 ширхэг хувьцаа 194.1 сая төгрөгийн үнийн дүнтэйгээр хоёрдогч зах зээл дээр арилжаалагдсан үзүүлэлттэй байна.

ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ГРАФИК






Thank You

SOCIAL MEDIA

-  Mongol Basalt JSC
-  Mongol_Basalt
-  www.basaltwool.mn

CONTACT

-  monbasalt@rockwool.mn
-  +976 75114444, 77006768
-  БГД, 29-р хороо, үйлдвэрийн бүс 1-35,
Монгол Базальт ХК-ийн байр

